

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН
ГУРАВДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2020.03.01-2020.03.31/

2020 оны 03 дугаар сарын 31

Даланзадгад хот

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд

1.1 Түр ирэгчийн бүртгэл, хасалт:

Тайлант хугацаанд 1 гадаадын иргэнд түр ирэгчийн бүртгэл, 1 иргэний хасалт хийж ажилласан байна.

1.2 Торгуулийн арга хэмжээ авагдсан талаар:

Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.4-т заасны дагуу нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн БНХАУ-ын 1 иргэнд 100.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч улсын төсөвт нийт 100.000 төгрөгийг төвлөрүүлэн, зөрчлийг арилгаж ажилласан.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

Байгууллагын даргын 2020 оны 01,03,04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг долоо хоногийн даваа гариг бүр холбогдох нэгжид хүргүүлэн ажиллаж байна. Мөн шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг 03 дугаар сарын 13, байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг тус тус гарган 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлэн ажилласан.

Тус газрын албан хаагчдын сургалтад хамрагдсан байдал, цаашид хамрагдах хүсэлтэй сургалтын судалгааг гаргуулан 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлэн ажилласан.

Улсын онцгой комиссын 2020 оны 02-06 дугаар тогтоол, байгууллагын даргын 2020 оны 04 дүгээр албан даалгавар, 2020 оны А/79 дүгээр тушаалыг нийт албан хаагчдад танилцуулан гарын үсгээр баталгаажуулан холбогдох нэгжид тус тус хүргүүлэн ажилласан болно.

Хүний нөөцийн програмд 21 албан хаагчийн цалин, хоолны хөнгөлөлт, төрийн захиргааны 8 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, зэрэг дэв, төрийн үйлчилгээний 1 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл зэрэг мэдээллийг тухай бүр нь шивж ажилласан.

2.1.Өргөдөл, гомдлын мэдээ

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/-0
- Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо-0
- Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо-0
- Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0

- Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-1/
- Төв газарт явуулсан бичиг /илтгэх хуудас-6/
- Явуулсан бичиг /албан тоот-10/
- Бусад байгууллагаас ирсэн бичиг-12
- Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-0

2.2. Санхүү, хангалт үйлчилгээний чиглэлээр:

Энэ оны 03 дугаар сард 42,923,700 төгрөгийн санхүүжилт авч нийт 21 албан хаагчийн цалинд 21,126,295.15 төгрөгийг олгож, нийгмийн даатгалын шимтгэлд 2,733,186.94 төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох байрны түрээсийн зардалд 2,309,395.40 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 3,523,487 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 898,600 төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 415,000 төгрөгийн гүйлгээ хийж Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан гүйлгээ хийж ажилласан байна.

Тус газрын 2020 оны 02 дугаар сарын шилэн дансны мэдээллийг цахим сайтад байршуулж тоон мэдээг дараа сарын 02-ны дотор холбогдох нэгжид хүргүүлж ажилласан.

2.3. Мэдээлэл технологийн чиглэлээр:

Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд албан хаагчдаас сүлжээ тасалдсан, компьютерийн хэвийн бус ажиллагаатай холбоотой нийт 3 дуудлага ирүүлснийг тухай бүр засч сайжруулан ажилласан.

Тус газар нь интернэт, дотоод сүлжээг нэг байгууллагаас авах болсон тул Өмнөговь аймаг дахь Монголын цахилгаан холбоо ХК-д 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 13/25 дугаар албан бичгээр хүсэлтийг уламжлан гэрээг цуцлан Мэдээлэл холбоо сүлжээний компаниас интернэтийн холболтыг хийлгэн ажилласан.

Гурав. Бусад

3.1 БНХАУ-д бүртгэгдсэн шинэ коронавирусын дэгдэлт ихэссэнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Өмнөговь аймгийн онцгой комисс болон байгууллагын даргын гаргасан шийдвэрүүдийг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. Тухайлбал, албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор халуун чацаргана, витамин, гар ариутгах бодисоор ханган, албаны өрөөнүүдийн цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтлийг сайжруулан ажиллаж байна. Мөн байгууллагын даргын гаргасан албан даалгаврын биелэлт, уг вирусээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн гаргаж холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.

ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР